

**МОНГОЛ УЛСЫН 2009 ОНЫ ЭХНИЙ
7 САРЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны 7 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргалаа. 2009 оны эхний 7 сарын орлого, зарлагын байдлыг авч үзвэл:

А. Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр нийт орлого 990.1 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 3.6 тэрбум төгрөгөөр буюу 0.4 хувиар дутуу биелж, 2008 оны мөн үеийнхээс 20.9 хувиар буюу 261.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрээр нь авч үзвэл 79.1 хувь нь татварын орлогоос, 19.5 хувь татварын бус орлогоос, 1.3 хувь нь тусламжийн орлогоос, 0.2 хувь нь хөрөнгийн орлогоос тус тус бүрдсэн байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлогын төрлөөр авч үзвэл:

ТӨСВИЙН ОРЛОГО	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үеийн	жилийн Төлөв.	2009 ОНЫ 2-Р САР		ХУВЬ		ӨРҮҮ
	1	2	Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 : 2)	(4 - 3)
(Тэрбум төгрөг)							
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,251.7	1,972.9	993.7	990.1	99.6	50.2	-3.6
УРСГАЛ ОРЛОГО	1,248.0	1,948.5	981.7	975.6	99.4	50.1	-6.1
ТАТВАРЫН ОРЛОГО	1,092.4	1,618.6	784.6	783.0	99.8	48.4	-1.6
Орлогын албан татвар	471.3	372.8	200.6	208.1	103.7	55.8	7.5
ААН-ийн орлогын албан татвар	163.4	223.5	115.6	92.8	80.3	41.5	-22.7
Хувь үний орлогын албан татвар	59.6	98.7	63.6	68.9	108.3	69.8	5.3
Зарим үтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	248.4	50.7	21.4	46.4	216.5	91.5	24.9
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	113.2	251.6	124.9	135.7	108.6	53.9	10.7
Өмчийн татвар	4.8	10.3	5.8	6.0	102.2	57.9	0.1
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	298.8	629.3	288.0	280.2	97.3	44.5	-7.8
Гадаад худалдааны орлого	87.1	163.2	72.6	65.7	90.5	40.3	-6.9
Бусад татвар	117.3	191.5	92.7	87.3	94.2	45.6	-5.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	155.6	329.9	197.0	192.6	97.8	58.4	-4.4
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	2.3	2.4	3.0	1.7	57.8	72.2	-1.2
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1.4	22.0	9.1	12.8	140.9	58.3	3.7

Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлтийг төсөв тус бүрээр авч үзвэл:

- Улсын төсвийн орлого 6.0 хувиар буюу 47.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу биелсэн байна. Үүнд дотоодын бараа, үйлчилгээний албан татвар 3.1 хувиар буюу 8.8 тэрбум, гадаад худалдааны орлого 9.5 хувиар буюу 6.9 тэрбум, бусад татварын орлого 5.8 хувиар буюу 2.9 тэрбум, татварын бус орлого 2.7 хувиар буюу 4.9 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс дутуу төвлөрсөн нь нөлөөлсөн байна.
- Орон нутгийн төсвийн орлого 1.6 хувиар буюу 2.3 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү төвлөрсөн байна. Орлогын албан татвар 8.3 хувиар буюу 5.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс илүү төвлөрч, бусад татвар 5.7 хувиар буюу 2.4 тэрбум, татварын бус орлого 4.6 хувиар буюу 0.5 тэрбум, хөрөнгийн орлого 42.2 хувиар буюу 1.2 тэрбум

төгрөгөөр тасалдсан байна. Өмнөговь лизенцийн төлбөрийн орлого 1.9 тэрбум, хувьцааны ноогдол ашгийн орлого 0.7 тэрбум төгрөгөөр тус тус тасарч, ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 0.6 тэрбум төгрөгөөр давж биелснээр аймгийн нийт дүнгээр 1.7 тэрбум төгрөгөөр орлого тасарсан байна. Баян-өлгий, Сүхбаатар, Төв, Увс аймгийн орлого 0.4, 0.6, 0.4, 0.4 тэрбум төгрөгөөр харгалзан давж биелсэн байна. Нийслэл Улаанбаатар хотын хувь хүний орлогын албан татварын 3.2 тэрбум төгрөгөөр давж, хөрөнгийн орлого 1.3 тэрбум төгрөгөөр дутуу биелснээр нийтүндээр төлөвлөгөөнөөс 1.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн орлого д алтны үнийн өсөлтийн татварын орлого 46.4 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөөнөөс 24.9 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 267.6 тэрбум төгрөгт хүрч 2.8 хувиар буюу 7.3 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлжээ. Нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох 96.2 тэрбум төгрөгийн татаас, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр харуулвал:

ТӨСВИЙН ОРЛОГО	Улсын өсөв		Орон нутгийн өсөв		МУХС		НДС	
	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ
	(Тэрбум.төгрөг)							
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	789.0	741.9	145.3	147.6	21.8	47.7	260.3	267.6
УРСГАЛ ОРЛОГО	703.1	656.9	131.8	135.4	21.8	47.7	164.0	171.4
ТАТВАРЫН ОРЛОГО	519.1	477.7	119.2	123.3	21.4	46.4	164.0	171.4
Орлогын албан татвар	115.6	92.8	63.6	68.9	21.4	46.4	0.0	0.0
ААН-ийн орлогын албан татвар	115.6	92.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувь хүний орлогын албан татвар	0.0	0.0	63.6	68.9	0.0	0.0	0.0	0.0
Зарим үтгээгдэхүүний үнийн өсөлтийн а/татвар	0.0	0.0	0.0	0.0	21.4	46.4	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	164.0	171.4
Өмчийн татвар	0.0	0.0	5.8	6.0	0.0	0.0	0.0	0.0
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	280.6	271.8	7.4	8.4	0.0	0.0	0.0	0.0
Гадаад худалдааны орлого	72.6	65.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар	50.3	47.3	42.4	40.0	0.0	0.0	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	184.0	179.1	12.6	12.2	0.4	1.3	0.0	0.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	3.0	1.7	0.0	0.0	0.0	0.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	85.9	85.0	10.5	10.5	0.0	0.0	96.2	96.2

Б. Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны эхний 7 сарын нийт зарлага 1533.9 тэрбум төгрөг, үүнээс улсын төсвийн зарлага 1201.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн зарлага 1271.7 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт зарлагын 82.9 хувийг, улсын төсвийн зарлага 1018.2 тэрбум төгрөг болж, нийт төлөвлөгдсөн зардлын 84.8 хувийг тус тус санхүүжүүлсэн байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн тавьж олгосон бөгөөд халамжийн сангаас хүүхдийн мөнгөний хөтөлбөрт 27.8 тэрбум төгрөг, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжинд 3.8 тэрбум төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламжинд 8.9 тэрбум төгрөг, шинэ гэр бүлд олгох мөнгөн тусламжид 9.5 тэрбум төгрөг, алдар цолтой ахмад, ахмадуудад нийт 3.9 тэрбум төгрөг, жирэмсэн нярай эхчүүдэд 9.0 тэрбум төгрөгийн халамжийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Нэгдсэн төсвийн нийт урсгал зардлын 12.5 хувь нь буюу 123.0 тэрбум төгрөг нь нийгмийн халамжийн сангийн зардал, 37.3 хувь буюу 368.1 тэрбум төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нийтдээ 49.8 хувь буюу 491.1 тэрбум төгрөг нь цалин, тэтгэвэр тэтгэмжийн зардал эзэлж байна.

Орон нутгийн төсвийн зарлага 126.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардлын 88.7 хувийг санхүүжүүлсэн байна. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн зарлага төлөвлөгдсөн зардлын 55.1 хувь буюу 87.6 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн зарлагатөлөвлөгдсөн зардлын 100.2 хувь буюу 253.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

ӨСВИЙН ЗАРЛАГА	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны	жилийн	2009 ОНЫ 2-Р САР		ХУВЬ		ӨРҮҮ
	мон үеийн	Төлөв.	Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 : 2)	(4 - 3)
	1	2	3	4	5	6	7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,227.5	2,314.2	1,533.9	1,271.7	82.9	55.0	-262.2
УРСГАЛ ЗАРДАЛ	968.7	1,784.7	1,137.0	985.9	86.7	55.2	-151.1
Бараа, үйлчилгээний зардал	563.2	931.9	601.3	541.4	90.0	58.1	-59.9
Цалин хөлс	306.2	586.6	359.0	337.1	93.9	57.5	-21.9
Нийгмийн даатгалын шимтгэл	26.3	55.7	34.3	31.0	90.2	55.6	-3.4
Бараа, үйлчилгээний бусад зардал	257.1	345.3	242.3	204.2	84.3	59.1	-38.1
Зээлийн үйлчилгээний төлбөр	10.7	54.5	16.1	14.2	88.3	26.0	-1.9
Татаас ба шилжүүлэг	394.7	798.3	519.5	430.3	82.8	53.9	-89.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	197.6	428.1	351.7	165.6	47.1	38.7	-186.1
Догоод эх үүсвэрээр:	195.9	396.1	332.3	155.5	46.8	39.3	-176.8
Гадаад эх үүсвэрээр	1.7	32.0	19.4	10.1	52.0	31.6	-9.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	61.2	101.4	45.3	120.2	265.7	118.6	75.0
УРСГАЛ ТЭНЦЭЛ	279.4	163.8	-155.3	-10.3	6.6	(6.3)	145.0
НИЙТ ТЭНЦЭЛ	24.3	-341.3	-540.2	-281.6	52.1	82.5	258.6

Эргэж төлөгдөх цэвэр зээл :

Монгол Улсын Засгийн газар 2009 оны 7 дугаар сарын гүйцэтгэлээр гадаадын хандивлагч орнуудаас 79.3 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төслийн зээлийн хөрөнгийг авч ашиглахаар өлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 39.2 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг авч ашигласан гүйцэтгэл гарчээ.

Төсвийн тэнцэл:

Тайлант үед Монгол Улсын нэгдсэн өсвийн урсгал тэнцэл 10.3 тэрбум төгрөгийн, нийт тэнцэл 281.6 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 142.3 тэрбум, нийт тэнцэл 276.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Төсвийн нийт алдагдлыг дараах байдлаар санхүүжүүлэхээр

Үүнд: 1. Засгийн газрын бонд гаргаж 60.0 тэрбум төгрөгийн,

2. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн эрсдлийн хэсгээс 149.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрүүдийг бүрдүүлсэн байна.

-----oOo-----